



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/13/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11. Шилэн дансны мэдээлэл	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3. Менежментийн захидал	12
3.1 Дотоод хяналттай холбоотой асуудал	12
4.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	22
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СХС	Сум хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ДОА	Дорнод аймаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



1. Аудитын гэрчилгээ


**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
21000 Дорнод аймаг, Хэргэн сум 7-р баг
ЗДТТ-ын II байр, Утас/Факс: 7038-4203

БАЯНТҮМЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГА А.ЭНХТҮВШИН ТАНАА

Аодо, 03.15 № 316

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баянтүмэн сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянтүмэн сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Баянтүмэн сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520222



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит





2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч А.Энхтүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баянтүмэн сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж гүйцэтгэв.

Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянтүмэн сумын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Баянтүмэн сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2019 онд Баянтүмэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянтүмэн сумын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 1,618.9 сая төгрөгийн 2 хувь буюу 32,3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 41,7 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны гүйцэтгэлийн зардал өссөнтэй холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгайн сангийн, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 8 байгууллагын санхүүгийн тайлан аудитад хамрагдсан.



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 5 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгч, 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа.

Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 7,798.7 мянган төгрөгийн алдаа, 361.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 795.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 6,642.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар " Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 2.2.1 дэх заалтыг зөрчин сумын Засаг даргын захирамжаар нийт 361,400.0 төгрөгийг урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох.

2. Төсвийн тухай хууль, Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар " Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ыг зөрчин Засаг даргын захирамжаар нийт 795.0 мянган төгрөгийг журамд заагдаагүй арга хэмжээнд зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 3,404.2 мянган төгрөгийн залруулга хийлээ. Үүнд:

- Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төв: Төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй олгосон 3,404.2 мянган төгрөгийн эмийг орлогод аваагүй байсныг санхүүгийн тайланд залруулсан байна.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

~~мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,626.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 159.5 сая, эцсийн үлдэгдэл 100.9 сая төгрөг болж, 58.6 сая төгрөгөөр буурсан байна.~~

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Касст байгаа бэлэн мөнгө</u>				
<u>Банканд байгаа бэлэн мөнгө</u>	159.5	100.9	-58.6	36,7
<u>Замд яваа мөнгөн хөрөнгө</u>				
<u>Хадгаламж</u>				
<u>Дүн</u>	159.5	100.9	-58.6	36.7



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 100.9 сая төгрөгөөс төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 100.8 сая төгрөг, арилжааны банкны дансанд 0.1 сая төгрөг барьцаа дансанд байршиж байна.

2.8.2 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 158.4 сая, эцсийн үлдэгдэл 203.6 сая төгрөг болж 46.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын <u>үлдэгдэл</u>	<u>/сая төгрөг/</u>		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	6.7	6.7	0.0
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	151.7	196.9	130.5
Зээлийн авлага			
Дүн	158.4	203.6	129.2

Авлагын үлдэгдэлд шинжилгээ хийхэд нийт авлагын 53.4 хувь буюу 108.7 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн 102.0 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг шүүхэд хандсан байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн Санхүүгийн хяналт аудитын албанаас 2013 онд тогтоосон 1.2 сая төгрөгийн төлбөрийн акт одоог хүртэл барагдаагүй байна.
- Цэцэрлэгийн багш нарыг төрийн албанаас үндэслэлгүй халсантай холбоотой 5.5 сая төгрөгийн авлагыг төлүүлэх шүүхийн шийдвэр 2015 онд гарсан ч одоог хүртэл хэрэгжээгүй байгаа бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хандсан байна.

2.8.3 Бараа материал

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 170,0 сая, эцсийн үлдэгдэл 203,2 сая төгрөг болж, 33,2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын <u>үлдэгдэл</u>	<u>/сая төгрөг/</u>		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	4.4	4.4	0.0
Эм боох материал	0,07	0,07	0.0
Бичиг хэргийн материал	1,5	2,0	0,5
Аж ахуйн материал	53,8	63,6	9,8
Сэлбэг хэрэгсэл	3,0	3,4	0,4
Түлш шатах тослох материал	1,1	1,1	0.0
Барилгын засварын материал	4,1	4,1	0.0
Хүнсний материал	0,001	0,01	0,009
Бусад хангамжийн материал	16,4	38,7	22,3
Мал амьтад	85,6	85,8	0,2
Дүн	170,0	203,2	33,2

Бараа материалын үлдэгдэл нь 33,2 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамж болон аж ахуйн материалын хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Үүнд ОНХС-гийн хөрөнгө



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

оруулалтаар худалдан авсан, түймэр унтраах зориулалт бүхий жижиг багаж хэрэгслийн дүн голлох нөлөөтэй байна.

2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна~~ эхний үлдэгдэл 3,235.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,112.9 сая төгрөг болж, 877.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж орон сууц	1034,7	1243,2	208,5
Авто тээврийн хэрэгсэл	197,6	258,6	61,0
Машин тоног төхөөрөмж	260,6	304,5	43,9
Тавилга аж ахуйн эд хогшил	152,1	165,7	13,6
Зам гүүрийн байгууламж	299,0	299,0	0
Түүх соёл музейн дурсгалт зүйл	31,0	31,0	0
Бусад үндсэн хөрөнгө	1020,8	1569,9	549,1
Ном	9,7	10,3	0,6
Программ хангамж	2,2	3,1	0,9
Бусад биет бус хөрөнгө	227,5	227,6	0,1
Дүн	3235,2	4112,9	877,7

Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвөөс худалдан авсан 27.7 сая, хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийн харьяалах төсөвт байгууллагад хөрөнгийн орлогод 753.2 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 96.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд хөрөнгө бууруулах ажил гүйлгээ гараагүй байна.

2.8.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,025.3 сая, эцсийн үлдэгдэл 3,699.8 сая төгрөг болж, 674.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Хүснэгт № 31. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт -/	Дүнд эзлэх хувь
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	<u>964,3</u>	<u>964,3</u>		
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	<u>1,317.5</u>	<u>1,992.0</u>	<u>674,5</u>	
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	<u>743,5</u>	<u>743,5</u>		
Дүн	3,025.3	3,699.8	674,5	122,2

Засгийн газрын оруулсан капитал болон хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд өөрчлөлт гараагүй байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Баянтүмэн сумын 2019 оны орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 24.0 сая төгрөгөөр батлагдсан нь гүйцэтгэлээр 39.4 сая төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөөг 164.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	12,5	15,8	3,3	126,4
Шууд бус орлого	0,5	2,6	2,1	520,0
Бууны албан татвар	1,2	1,2	-	100,0
Улсын тэмдэгтийн хураамж	1,5	1,5	-	100,0
Хүү торгуулийн орлого	2,0	2,3	0,3	115,0
Хадгаламжийн хүүгийн орлого	2,8	5,3	2,5	189,2
Бусад нэр заагдаагүй орлого	3,5	10,7	7,2	305,7
Нийт дүн	24,0	39,4	15,4	164,1

Сумын төсвийн орлого 15.4 сая төгрөгөөр давж биелсэн нь хадгаламжийн хүүгийн орлого, шууд бус орлого, бусад нэр заагдаагүй орлогууд 90-ээс дээш хувиар давж биелсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,759.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,478.3 сая төгрөгийг урсгал зардалд, 214.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,452.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24.1 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 256.7 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,452.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 8.4 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 204.3 сая төгрөгийн санхүүжилт орсон нь нийт 1,513.3 сая төгрөг байна. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгож, сум хөгжлийн сангийн эргэн төлөлт хангалтгүй байснаас шалтгаалж санхүүжилт нь төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1.642.0 сая төгрөг буюу 93.3 хувьтай байгаагийн 4.0 хувь нь санхүүжилт дутуу төвлөрсөн, 2.7 хувь нь төсөвт байгууллагуудын орон тоо дутуу ажилласан, хэмнэлт үүссэн зэргээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Засаг даргын нөөц хөрөнгөөс 25,000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 36,992.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,583.1 мянга, нийт 79,018.9 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс: Цалингийн урамшуулалд 201.1 мянга, тогтмол зардалд 44.4 мянга, хангамж бараа материалын зардалд 18,575.0 мянга, нормативт зардалд 7,495.6 мянга, эд хогшил урсгал засварт 5,015.1 томилолтын зардалд 3,502.1, бусад зардалд 44,185.6 мянга нийт 79,018.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянтүмэн сум нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.



2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 06 сарын 15-ны өдрийн албан бичгээр Төрийн аудитад ирүүлсэн байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянтүмэн сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд аудит хийх явцад сумын цэцэрлэг нь 5,422.2 мянган төгрөг, ерөнхий боловсролын сургууль нь 1,220.1 мянган төгрөг, нийт 6,642.3 мянган төгрөгийн он дамжсан авлагын үлдэгдэлтэй байна.

3.1.2 Эрсдэл: Төсвийн сахилга бат алдагдах, хөрөнгийн эргэц удаашрах.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль мөрдөн ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	486,943,520.37	507,772,471.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	159,392,374.36	100,901,800.96
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	159,392,374.36	100,901,800.96
3121	Төгрөг	159,392,374.36	100,901,800.96
31211	Төрийн сангийн харилцах	158,529,580.47	100,822,747.57
31213	Арилжааны банк дахь харилцах	862,793.89	79,053.39
33	АВЛАГА	157,483,677.00	203,677,015.20
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,784,902.00	5,499,902.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	8,109,590.00	3,313,117.20
335	Бусад авлага	143,589,185.00	194,863,996.00
3351	Байгууллагаас авах авлага	825,868.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	142,763,317.00	194,863,996.00
35	БАРАА МАТЕРИАЛ	170,067,469.01	203,193,655.13
351	Түүхий эд материал	4,488,049.20	4,488,049.20
35110	Тусгай зориулалттай материал	4,417,478.50	4,417,478.50
35130	Эм боох материал	70,570.70	70,570.70
354	Хангамжийн материал	80,008,294.81	113,134,480.93
35410	Бичиг хэргийн материал	1,471,650.00	2,002,250.00
35420	Аж ахуйн материал	53,819,390.15	63,598,702.03
35430	Сэлбэг хэрэгсэл	3,047,640.00	3,486,300.00
35440	Түлш, шатах тослох материал	1,154,323.33	1,154,322.47
35450	Барилгын засварын материал	4,101,000.00	4,101,000.00
35460	Хүнсний материал	1,309.40	10,000.00
35470	Бусад хангамжийн материал	16,412,981.93	38,781,906.43
35600	Мал амьтад	85,571,125.00	85,571,125.00
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	2,542,546,653.30	3,192,048,610.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,542,546,653.30	3,192,048,610.07
391	Газар	185,810,000.00	-
392	Биег хөрөнгө	2,314,710,903.30	2,963,565,130.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,034,740,557.13	1,243,233,543.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(47,615,588.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	197,603,727.60	258,598,727.60
39204	Хуримтлагдсан элэгдэл	(139,169,223.87)	(162,481,373.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	260,649,999.22	304,592,770.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(166,730,565.44)	(199,095,415.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	152,116,425.31	165,723,033.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(75,122,890.72)	(90,942,118.60)
39209	Зам, гүүрийн байгууламж	299,014,438.00	299,014,438.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(23,921,154.96)	(35,881,732.44)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	31,000,000.00	31,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,020,832,212.11	1,569,981,057.11



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39215	Хуримтлагдсан элэгдэл	(286,069,975.08)	(382,948,295.12)
39217	Ном	9,767,354.00	10,386,084.00
393	Биет бус хөрөнгө	42,025,750.00	228,483,479.98
39301	Програм хангамж	2,219,181.00	3,151,381.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,645,431.00)	(1,929,901.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,452,000.00	227,262,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,029,490,173.67</u>	<u>3,699,821,081.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,095,799.83</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,095,799.83	-
413	Өглөг	4,095,799.83	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,354,938.83	-
4136	Бусад өглөг	1,740,861.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,651,736.00	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	89,125.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,025,394,373.84</u>	<u>3,699,821,081.36</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,025,394,373.84	3,699,821,081.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	964,283,059.94	964,283,059.94
51101	Өмч: - төрийн	964,283,059.94	964,283,059.94
512	Хуримтлагдсан үр дүн	1,317,565,062.05	1,991,991,769.57
51210	Өмнөх үеийн үр дүн	1,841,162,581.98	1,317,565,062.05
51220	Тайлант үеийн үр дүн	(523,597,519.93)	674,426,707.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	743,546,251.85	743,546,251.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,029,490,173.67</u>	<u>3,699,821,081.36</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,949,116,792.73	3,031,031,701.09
11	ТАТВАРЫН ОРЛОГО	18,549,391.05	21,093,397.55
110	Орлогын албан татвар	15,889,861.00	18,341,896.55
1100	Хувь хүний орлогын албан татвар	15,889,861.00	18,341,896.55
110002	Үйл ажиллагааны орлого	1,687,660.00	2,560,467.05
110008	Шууд бус орлого	14,202,201.00	15,781,429.50
113	Хөрөнгийн албан татвар	1,080,000.00	1,260,000.00
113002	Бууны албан татвар	1,080,000.00	1,260,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,579,530.05	1,491,501.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,579,530.05	1,491,501.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,579,530.05	1,491,501.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	369,522,303.68	988,207,912.67
120	Нийтлэг татварын бус орлого	366,705,863.68	924,049,822.67
120002	Хүүгийн орлого	2,694,794.68	5,294,385.27
120003	Торгуулийн орлого	150,000.00	2,317,958.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	339,876,769.00	905,664,487.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,451,207.00	32,397,741.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,832,460.00	1,188,000.00



Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	304,593,102.00	872,078,745.79
120009	Бусад орлого	23,984,300.00	10,772,992.00
121	Хөрөнгийн орлого	2,816,440.00	-
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө бордуулсны орлого	2,816,440.00	-
122	Тусламжийн орлого	-	64,158,090.00
122001	Хандив тусламж /дотоод/		8,363,390.00
122002	Хандив тусламж /гадаад/		55,794,700.00
